


1. Проекцын аль нэг хавтгайд перпендикуляр байршилтай хавтгайг сонгоно уу.


- А. хэвтээ түвшний хавтгай
 С. ерөнхий байршилтай хавтгай

- В. түвшний байршилтай хавтгай
 D. проекцлогч байршилтай хавтгай

2. Хэвтээ түвшний байршилтай хавтгайг дүрсэлсэн зургийг сонгоно уу.




3. Хажууд проекцлогч байршилтай хавтгайн тэгш өнцгийн проекцыг сонгоно уу.







4. Проекцлогч байршилтай хавтгайн бодит хэмжээг хавтгайн мөрөөр эргүүлэх аргаар зөв дүрсэлсэн зургийг сонгоно уу.




A.



B.




C.




D.


5. Зурагт үзүүлсэн дамжуулгын бүдүүвч зургийг сонгоно уу.




A.



B.





C.



D.

6. Зурагт үзүүлсэн “Хавчигч”-ийн угсрааны зургаас хэддүгээр деталийг детальчлан зурсан байна вэ? Зөв хариуг сонгоно уу.




А. детал-1

В. детал-2

С. детал-3

Д. детал-5

7. Зурагт үзүүлсэн “Хээ гаргагч” дамрын угсрааны зургийг уншаад, деталуудыг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.



- А. 1-их бие, 2-эрэг, 3-даравч, 4-боолт, 5-өнхрөгч дамар
В. 1-их бие, 2-боолт, 3-даравч, 4-эрэг, 5-өнхрөгч дамар
С. 1-их бие, 2-өнхрөгч дамар, 3-эрэг, 4-даравч, 5-боолт
Д. 1-их бие, 2-өнхрөгч дамар, 3-боолт, 4-даравч, 5-эрэг

8. Дундад зууны үед Готик хэв маягтай уран барилгын зургийг сонгоно уу.




A.



B.



C.



D.

9. Монгол улсад нэг хүнд эзэмшүүлэх газрын хэмжээг сонгоно уу.

A. 20x25м

B. 22x25м

C. 25x28м

D. 26x28м


10. Хаалга нь нэг ба хоёр далавчтай, эвхэгддэг, гулсдаг, эргэдэг болон өргөж онгойдог гэх мэт олон янз байдаг. Эвхэгдэж онгойдог хаалганы тэмдэглэгээг сонгоно уу.



A.



B.




C.




D.


11. Барилгын давхрын план зурагт хэмжээг зөв тэмдэглэсэн зургийг сонгоно уу.




A.



B.




C.



D.

12. Зурагт үзүүлсэн байшингийн хийцийн элементүүдийг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.




A. 1-дээвэр, 2-дээврийн хучилт, 3-гадна фасад, 4-шалны хучилт, 5-хаяавч

B. 1-дээвэр, 2-дээврийн хучилт, 3-даацын хана, 4-шалны хучилт, 5-хаяавч

C. 1-шувуун нуруу, 2-давхрын хучилт, 3-хаалга, цонх, 4-шалны хучилт, 5-суурь

D. 1-шувуун нуруу, 2-таазны хучилт, 3-хана, 4-шалны хучилт, 5-суурийн зангилаа

13. Ландшафтын план зурагт хашааг дүрслэх график тэмдэглэгээг сонгоно уу.



A.

B.

C.

D.

14. Орон зайн бүтэц үүсгэн зохиомжлох аргуудыг ажиглаад, жишээ зурагтай зөв харгалзуулсан сонгоно уу.


1. зүсэлтээр хавтгайг орон зайн бүтцэд хувиргах
2. нугалаасаар хавтгайг орон зайн бүтцэд хувиргах
3. нугалаасаар хавтгайг товгор гадаргуун бүтцэд хувиргах



a.



b.



c.

A. 1-a, 2-b, 3-c

B. 1-a, 2-c, 3-b

C. 1-c, 2-b, 3-a

D. 1-c, 2-a, 3-b

15. Эргэлдэх хөдөлгөөнийг тодорхой зайд дамжуулахад ихэвчлэн механик дамжуулга ашиглана. Механик дамжуулгыг дотор нь үрэлтийн ба харьцалтын гэж хоёр ангилна. Үрэлтийн дамжуулгад хамаарах механизмыг сонгоно уу.

- A. шүдэт механизм
C. оосорт механизм

- B. гинжит механизм
D. араат механизм

16. Хөдөлгөөний чиглэл, өнцгийг өөрчлөх, хол зайд дамжуулах боломжтой механик дамжуулгыг сонгоно уу.

- A. шүдэт дамжуулга
C. үрэлтэт дамжуулга

- B. гинжит дамжуулга
D. оосорт дамжуулга

17. Техникийн бүтээл хийхдээ эд анги, мөчүүдийн хөдөлгөөний байрлал, хөдөлгөөн хийх орон зайн хэлбэрийг урьдчилан тооцоолон, зурах аргыг сонгоно уу.

- A. хөдөлгөөний тэгшитгэл бодох
C. хөдөлгөөний траектор байгуулах

- B. кинематик тэмдэглэгээ зурах
D. кинематик схем байгуулах

18. Цахилгаан сайн дамжуулдаг ба цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч хоёрын дундах саармаг шинж чанарыг үзүүлдэг материалыг сонгоно уу.

- A. хуванцар B. хагас дамжуулагч C. керамик D. унтраалга

19. Хагас дамжуулагч материалаар хийгдсэн, аж үйлдвэрт бүтээгдэхүүний тооллуурт болон хяналтын систем хэмжигдэхүүнийг зохицуулах зэрэгт хэрэглэдэг мэдрэгчийг сонгоно уу.


- A. фото диод
C. фото эсэргүүцэл

- B. зай мэдрэгч
D. хөдөлгөөн мэдрэгч

20. Таймер (timer) бол тодорхой хугацаанд, заагдсан дохиог гаргах функцтэй микро схем юм. Интеграл таймер NE555 микро схемийн 1 номерын хөлний үүрэг зориулалтыг сонгоно уу.

- A. гаралт B. тэжээл C. газардуулага D. дахин ачааллах

21. Техникт хөдөлгөөн гэдэг нь бие болон түүний хэсгүүд тодорхой орон зайд байрлалаа өөрчлөхийг хэлдэг. Механик системийн өнхрөх давших хөдөлгөөний зургийг сонгоно уу.



- A. B. C. D.

22. Техникийн эд ангиудын кинематик тэмдэглэгээг ашиглан кинематик схемийг зурдаг. Гол дээрх дамрын кинематик тэмдэглэгээг сонгоно уу.




- A. B. C. D.

23. Үрэлтэт дамжуулга нь шууд харьцалттай, уян холбоост гэсэн хоёр төрөл байдаг. Шууд харьцалттай үрэлтэт дамжуулгын зургийг сонгоно уу.




- A. B. C. D.

24. Механик дамжуулгаар хөдөлгүүрийн энергийг машины ажил гүйцэтгэх хэсэгт дамжуулдаг. Могой араат дамжуулгын зургийг сонгоно уу.




- A. B. C. D.

25. Электрон төхөөрөмжүүд нь олон төрлийн механик болон электрон элементээс бүрдэх бөгөөд өөр өөрийн үүрэг зориулалттай. Тэдгээр элементүүдийг хооронд нь ялгахын тулд график болон үсгээр тэмдэглэдэг. Транзисторын график тэмдэглэгээг сонгоно уу.



26. Тоон электроник төхөөрөмжийн элементүүдэд өгөгдсөн хүчдэлээр зохицуулагдана. Дэлгэц дээр гарах тоо 5 байх элементийн тоон утгыг сонгоно уу.




A.	A	B	C	D	E	F	G
	1	1	1	1	0	0	1

B.	A	B	C	D	E	F	G
	0	1	1	0	0	1	1

C.	A	B	C	D	E	F	G
	1	0	1	1	0	1	1


D.	A	B	C	D	E	F	G
	1	0	1	1	1	1	1

27. Оосорт дамжуулгын хөтлөгч гол дээрх дамрын диаметр 200 мм, хөтлөгдөгч дамрын диаметр 800 мм, хөтлөгч голтой холбоотой моторын эргэлт 50 эрг/мин. Хөтлөгдөгч голын эргэлтийг зөв тооцоолсон хариуг сонгоно уу.




- A. 12 эрг/мин
- B. 12.5 эрг/мин
- C. 20.5 эрг/мин
- D. 25 эрг/мин

28. Үрэлтэт дамжуулгын хөтлөгч дамрын диаметр $D_1=60$, хөтлөгдөгч дамрын диаметр $D_2=150$. Хөтлөгдөгч дамар минутад 80 эргэж байгаа бол хөтлөгч хөтлөгч дамар хэдэн удаа эргэх вэ? Зөв тооцоолсон хариуг сонгоно уу.




- A. 32 эрг/мин
- B. 60 эрг/мин
- C. 200 эрг/мин
- D. 210 эрг/мин

29. Зурагт өгөгдсөн кинематик тэмдэглэгээг ашиглан шүдэт дамжуулгын тооцооллыг хийгээрэй. I голын эргэлтийн давтамж 720 эрг/мин, $Z_1=20$, $Z_2=60$, $Z_3=16$, $Z_4=80$, $Z_5=20$, $Z_6=51$ бол IV голын эргэлтийн давтамжийг зөв тооцоолсон хариуг сонгоно уу.



- A. 18.8 эрг/мин
- B. 48 эрг/мин
- C. 280 эрг/мин
- D. 27500 эрг/мин

30. Электрон хэлхээний зарчмын схемийн сумаар заасан электроникийн элементүүдийг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.



- A. 1-лазер диод, 2-хэт авиа мэдрэгч, 3-эсэргүүцэл, 4-транзистор, 5-адаптер, 6-фото диод
- B. 1-лазер диод, 2-хэт авиа мэдрэгч, 3-эсэргүүцэл, 4- релей, 5-батерей, 6-хөдөлгөөн мэдрэгч
- C. 1-гэрлэн диод, 2-дуу гаргагч, 3-эсэргүүцэл, 4-транзистор, 5-конденсатор, 6-фото эсэргүүцэл
- D. 1-гэрлэн диод, 2-дуу гаргагч, 3-эсэргүүцэл, 4-релей, 5-батерей, 6-хөдөлгөөн мэдрэгч